

Хоёрдугаар алхам: Сургуулийн дотоод гадаад орчны үнэлгээ

Í èéò àíàè èààèíàò, °ð° òàñàèàà, èíðèáíð òàñòèòèèéí òàèààéí òýìæýý, äýðýèòççëýä, òííñæèèò, òàèààèò, àààððæòòèèèò, òíà òàýàààèä òòðø èèò àæèàèèèòüà òòñààè èíì èññ áàà áçðäççëýýí үнэлгээг хийв.

Àíàè èààèíàòüí òàèààèèòыг шинэчилсэн, тасалгааны температур өөрчлөгдөж, дулаан өрөө тасалгааны тоо нэмэгдсэн.

Óðàà, òííñæèèò байхгүй болсон их засвараар коридор залны шалыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн 100% сольсон.

Öííòíü òàì ààæèèòòàé, øèè òààððòàé байсныг бүрэн шинэчилж вакум цонхоор сольсон.

Анги кабинет өрөө тасалгааны агааржуулалтыг стандарт шаардлагад нийцүүлэн хийсэн.

Òàèààèòüí òíèáíèò ñàííàðòòüí хэмжээнд хийгдсэн ба хүчин чадал багатай íàì ààðàèòüí òííííç òç÷èí ÷àààè сайтай тогоогоор сольж өрөө тасалгаа, àíãèýäýн òàíà, øàèíü ýàäðýè èò байсныг их засвараар бүрэн засварлалаа.

Ñòðààèòüí òííííà ò°ò°°ð°ìæ øààðàèàà òàíàààççëé áòòòò,байсан бол 2010 онд биеийн тамирын заланд төгсөгчдийн хандив 1532200 төгрөгний хөрөгө оруулалт хийж тохижууллаа.

Гуравдугаар алхам: Үйл ажиллагааны төлөвлөгөө

- 1000 цэцгийн баяр зохион байгуулна.
- Багш нарын дунд байгаль орчны боловсрол олгох ур чадварын уралдаан зохион байгуулах.
- Аеэааí ààçàð áçð òííüí ñààðòàé áíèæ, òííüí àíãèèèí òàýò хог хаягдлыг боловсруулдаг болох
- Сургууль болон сумын хүн амын ундны хэрэгцээг хангах эрүүл аюулгүй орчин бүхий худаг нэмэх, ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих
- Багш нарын Иргэний боловсрол хичээлд сууж, зөвлөгөө өгөх.

Дөрөвдүгээр алхам: Хяналт үнэлгээ

Хяналт үнэлгээг сургуулийн удирдлагууд хийж ажлын явцтай танилцаж шаардлага тавьж ажилладаг. Үүний үр дүн ч харагдаж байгаа. Тухайлбал:

Анги бүрийн сурагчдын дунд “Эко сургууль болоход миний оролцоо” гэсэн ажил зохион байгуулж явууллаа.

Эко зөвлөл 14 хоногт 1 удаа цугларалт хийж хийсэн ажлаа дүгнэж, хийх ажлаа төлөвлөн хэлэлцэж байна.

Хогийн цэг байгууллаа. Биеийн тамирын талбайн орчим дээд хэсэг хогийн цэгтэй нийлсэн хог хаядалд дарагдсан байсныг цэвэрлэж эрүүлжүүллээ.Биеийн тамирын талбайг засварлаж тохижууллаа.

Халаалтын нэгдсэн системтэй болж галлагааны 3 амыг нэгтгэснээр түлшний зардал 2009 оныхоос 3,7 сая төгрөгөөр хэмнэгдлээ.

Тавдугаар алхам: Шинэ техник, технологи ашиглан сургалт зохион байгуулах
Төслийн зүгээс манай сургуульд иж бүрэн компьютер, багшийн гарын авлага, тараах материал, сурталчилгааны самбар, гадна хаяг, мод зэргээр дэмжлэг үзүүлсэн.

Зургаадугаар алхам: Орон нутгийн байгаль хамгаалахад олон нийтийн оролцоог дээшлүүлэх

Сумын нийт хөдөлмөрчдийн дунд “Эко сургууль болоход ард иргэдийн оролцоо” гэсэн сэдэвт хурал зохион байгуулж ямар үйл ажиллагаа явуулах, одоогийн байдалд дүн шинжилгээ хийсэн, төсөл хэрэгжсэнээр ямар үр дүнд хүрэх, төсөл хэрэгжүүлэхэд ард иргэдийн оролцоо хэрхэн нөлөөлөх талаар ярьж танилцууллаа.

Анги бүрийн сурагчдын дунд “Эко сургууль болоход миний оролцоо” гэсэн ажил зохион байгуулж явууллаа.

Иргэд хөдөлмөрчид нийт хүн амын дунд байгаль экологийн үзэл баримтлал тогтворжиж, нийт сумын хэмжээнд ногоон хэрэм төслийн хүрээнд 44930 мод бут сөөг, цөлжилтийг сааруулах төслөөр 1000 мод бут, байгууллага иргэд 4219 мод бут сөөг тарьсан. Мөн нийт сурагчдын дунд Байгалийн ухааны заах аргын нэгдлийн багш нар АХА, Дэвжээ зэрэг нийтийг хамарсан ажлыг жил бүр явуулж заншсан. Өнөө жил \2011.01.10\ Байгалийн ухааны багш нарын санаачилгаар 7а, 8а, 8б, 8в, 10а ангиудын эцэг эх – сурагчдын хамтарсан 1000 цэцэгтэй сургууль болоход Эцэг эхийн оролцоо сэдэвт сэдэвт “Дэвжээ” тэмцээн зохион явагдсан ба тус ангиудад Цэцгийн тавиур, 1анги хувцасны өлгүүр, нийт 60 ширхэг цэцгийн савтай боллоо.

2010 оны 12 сарын 8 нд Биологийн кабинетээс анги бүрээс 2 сурагч оролцуулж “Цэцэг тарих аргачлал” сургалт явуулж 1 сурагч 2-3 цэцэгтэй болсон ба эдгээр сурагчид ангийнхаа сурагчдад зааж өгөхөөр боллоо.

Долдугаар алхам: Байгальд ээлтэй сургууль болох зорилтыг хэрэгжүүлэх талаар бүх талын үйл ажиллагааг идэвхжүүлэх

Эко код, лого, уриа: Уриа: Манай сургууль “Миний нутгийн газраас сөөм газар цөлжилтөнд автах ёсгүй” Галдан Бошготын үр сад гэсэн уриатай.

Логооны тайлбар: Нарт дэлхийн чимэг, өөлд зоны өнийн түшиг Мөнх цаст Цамбагарав уулынхаа мөнгөн оройд гал тамгаа залсан. Гал тамгандаа 70 жилийн ойн 70-ын тоог шингээж урласан. Ариун тунгалаг Ховд голоо эдийн дээд хадагтай зүйрлэн мөнх оршихуйг билэгдэхийн зэрэгцээ байгаль орчноо шүтэн дээдлэх хайрлан хамгаалах нь хүн бүрийн үүрэг амьдралын үндэс гэсэн санааг үр хойчдоо өвлүүлэх нь хамгаас чухал гасэн утгаар дүрсэлсэн. Эрдэм номын гэгээн шидээр бүхнийг амилуулж байдаг эгэл өргөөгөө номтой зүйрлэсэн. Энэ бүхэн цогцоороо эрдмийн хур арвин байхыг билэгдсэн.

3. Тэргүүн туршлага: Сургуулийн Эко зөвлөлийн багш нарын санаачилгаар Эцэг эхийн дунд “Бидний өмнө тулгамдаж буй асуудал” сэдвийн хүрээнд Цөлжилт, Агаарын бохирдол зэрэг хичээлүүдийг зааж анх Гялгар цаасны хэрэглээг багасгаж, Даавуун тор хэрэглэж заншъя гэсэн уриаг дэвшүүлэн тавьж 50ш даавуун торыг Байгалийн ухааны бүх багш нарын (11) оролцоотойгоор оёж дээр нь Эко гэсэн бичгийг хонин холбоогоор оёж үнэгүй тараан өгч, эцэг эхчүүд сум орон нутгийн иргэдээс талархал хүлээж байсан.